



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 432

Хараат

“3000 уртын дуучид, морин хуурчид”-ын
наадамд оролцох ажлыг зохион байгуулах
комиссыг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8 үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын мэндэлсний 115 жилийн ой 2019 онд тохиохтой холбогдуулан, “3000 уртын дуучид, морин хуурчид”-ын наадамд оролцох ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: - Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: - Соёлын төвийн эрхлэгч

Гишүүд: - Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

- Санхүү албаны дарга

- Хэсгийн төлөөлөгч

- Хэсгийн цагдаа

- Мал эмнэлгийн тасгийн дарга

- ХАА-ийн тасгийн мэргэжилтэн

- Эрүүл мэндийн төвийн дарга

- Ерөнхий боловсролын сургуулийн захирал

- Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

- Соёлын төвийн бүжгийн багш

- Соёлын төвийн соёлын өвийн ажилтан

- Архив, бичиг хэргийн эрхлэгч

- 1 дүгээр багийн Засаг дарга

- 2 дугаар багийн Засаг дарга

- 3 дугаар багийн Засаг дарга

-4 дүгээр багийн Засаг дарга

- Цаг уурын өртөөний дарга

2. Монгол ардын уртын дуу “Уяхан замбуу тивийн наран”, “Энх мэндийн баяр”, “Эр бор харцага”, “Зээргэнтийн шил” болон “Дундговийн магтаал”, морин хуурын аялгуу “Үүлэн бор”, “Монгол аялгуу”, “Миний нутгийн бараа”, “Төв Халх жонон”, “Дундговийн магтаал”-ыг нийт иргэдэд зааж сургах ажлыг өрнүүлэн, хуурчдыг морин хуураар хангахад санаачилга гарган ажиллахыг багийн Засаг дарга нар, байгууллагын удирдлагууд, соёлын төвийн эрхлэгчид үүрэг болгосугай.

3. “3000 уртын дуучид, морин хуурчид”-ын наадмын бэлтгэл ажлыг хангах ажлын дэд хэсгүүдийг байгуулан, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнтэй зохион байгуулахыг комиссын даргат даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БУДЖАВ